



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/233-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит" ХХК Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ГАЛСАНЦЭРЭН ТАНАА

2024.02.23 № СЭА-0024/233/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 48,247.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	209,948,773.74	283,222,987.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,656,614.70	149,281,120.03
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	85,656,614.70	149,281,120.03
31210	Төгрөг	85,656,614.70	149,281,120.03
31211	Төрийн сангийн харилцах	85,656,614.70	149,281,120.03
35	БАРАА МАТЕРИАЛ	124,292,159.04	133,941,867.46
35400	Хангамжийн материал	124,292,159.04	133,941,867.46
35410	Бичиг хэрэг	332,460.00	
35420	Аж ахуйн материал	106,001,896.54	112,768,847.96
35460	Хүнсний материал	432,810.00	1,536,727.00
35470	Бусад хангамжийн материал	17,524,992.50	19,636,292.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,986,741,612.19	1,952,896,309.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,986,741,612.19	1,952,896,309.44
39200	Биет хөрөнгө	1,802,042,612.19	1,768,572,309.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,778,806,284.00	1,778,806,284.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-159,108,566.76	-198,199,399.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	198,333,380.52	241,365,470.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,330,418.67	-154,702,019.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,625,941.82	132,105,941.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,603,502.82	-63,112,891.87
39209	Зам гүүрийн байгууламж	9,053,207.37	9,053,207.37
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,944,285.72	-4,858,291.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,020,707.92	13,020,707.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,049,476.38	-5,350,878.74
39217	Ном	19,239,340.91	20,444,179.41
39300	Биет бус хөрөнгө	184,699,000.00	184,324,000.08
39301	Программ хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-375,000.00	-749,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	180,324,000.00	180,324,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,196,690,385.93	2,236,119,296.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,090.65	458,423.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,196,678,295.28	2,235,660,873.02
51	Засгийн газрын хувь оролцоо	2,196,678,295.28	2,235,660,873.02
51100	Засгийн газрын оруулсан капитал	607,985,818.53	607,985,818.53
51200	Хуримтлагдсан үр дүн	1,275,621,353.83	1,314,603,931.57
51210	Өмнөх үеийн үр дүн	1,275,621,353.83	1,275,621,353.83
51220	Тайлант үеийн үр дүн		38,982,577.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	313,071,122.92	313,071,122.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,196,690,385.93	2,236,119,296.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,305,531,736.05	1,402,045,475.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,194,166,322.22	60,591,451.50
120	Нийтлэг татварын бус орлого	2,194,166,322.22	60,591,451.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,934,800.00	9,478,248.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,613,600.00	2,956,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,321,200.00	6,522,248.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	0.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,062,504,009.56	36,302,828.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	124,727,512.66	14,810,375.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,111,365,413.83	1,341,454,024.15
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	982,529,700.00	1,258,408,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	982,529,700.00	1,258,408,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,800,800.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,800,800.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	124,034,913.83	83,045,624.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	124,034,913.83	83,045,624.15
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,108,853,440.77	1,363,062,897.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,853,440.77	1,363,062,897.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,524,045.77	1,280,348,319.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,521,688.71	907,765,523.40
210101	Үндсэн цалин	518,301,495.64	482,004,183.13
210102	Нэмэгдэл	189,969,342.27	389,763,213.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	14,250,850.80	35,998,126.35
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,054,069.44	112,605,832.72
210201	Тэтгэврийн даатгал	61,978,144.54	78,684,467.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,291,546.36	9,265,230.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,799,637.08	7,271,383.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,362,249.22	1,580,431.90
210205	Эрүүл мэндийн даатгал	13,622,492.24	15,804,319.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,079,706.63	73,121,124.15
210301	Гэрэл, цахилгаан	13,535,356.63	18,971,624.15
210302	Түлш, халаалт	42,414,350.00	41,249,500.00
210303	Цэвэр, бохир ус	11,130,000.00	12,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,499,620.00	10,336,700.00
210604	Урсгал засвар	15,499,620.00	10,336,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,978,600.00	9,921,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,613,600.00	2,956,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,365,000.00	6,965,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,918,460.99	154,893,766.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,351,350.00	27,268,924.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,876,713.62	13,062,610.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,690,397.37	114,562,231.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,329,395.00	82,714,578.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,329,395.00	82,714,578.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,329,395.00	51,353,878.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	31,360,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,196,678,295.28	38,982,577.74
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,196,678,295.28	38,982,577.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,118,300,213.83	1,350,932,272.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,934,800.00	9,478,248.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,934,800.00	9,478,248.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,934,800.00	9,478,248.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,613,600.00	2,956,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,321,200.00	6,522,248.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,111,365,413.83	1,341,454,024.15
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	982,529,700.00	1,258,408,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	982,529,700.00	1,258,408,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,800,800.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,800,800.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	124,034,913.83	83,045,624.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	124,034,913.83	83,045,624.15
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,002,715,599.13	1,242,893,666.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,715,599.13	1,242,893,666.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,973,344.13	1,159,075,171.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,509,598.06	907,473,086.15
210101	Үндсэн цалин	518,289,404.99	634,143,955.53
210102	Нэмэгдэл	189,969,342.27	237,331,004.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	14,250,850.80	35,998,126.35

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,054,069.44	112,451,936.71
210201	Тэтгэврийн даатгал	61,978,144.54	78,579,818.33
210202	Тэтгэмжийн даатгал	7,291,546.36	9,252,918.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,799,637.08	7,261,534.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,362,249.22	1,577,969.56
210205	Эрүүл мэндийн даатгал	13,622,492.24	15,779,695.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,079,706.63	73,121,124.15
210301	Гэрэл, цахилгаан	13,535,356.63	18,971,624.15
210302	Түлш, халаалт	42,414,350.00	41,249,500.00
210303	Цэвэр, бохир ус	11,130,000.00	12,900,000.00
2105	Нормативт зардал	9,122,000.00	5,490,600.00
210502	Хоол, хүнс	9,122,000.00	5,490,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,499,620.00	9,924,500.00
210604	Урсгал засвар	15,499,620.00	9,924,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,978,600.00	9,921,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,613,600.00	2,956,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,365,000.00	6,965,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,729,750.00	40,692,924.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,008,750.00	27,637,074.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,721,000.00	13,055,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,742,255.00	83,818,495.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,742,255.00	83,818,495.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,742,255.00	52,457,795.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	31,360,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	115,584,614.70	108,038,605.33
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,928,000.00	44,414,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,928,000.00	44,414,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,928,000.00	44,414,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,928,000.00	19,914,100.00
	Бусад хөрөнгө		24,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,928,000.00	-44,414,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	85,656,614.70	63,624,505.33
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	85,656,614.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,656,614.70	149,281,120.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	607,985,818.53	313,071,122.92	1,275,621,353.83	2,196,678,295.28
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	38,982,577.74	38,982,577.74
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,985,818.53	313,071,122.92	1,314,603,931.57	2,235,660,873.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,436,587,924.15	1,287,306,804.12	149,281,120.03	89.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,436,587,924.15	1,287,306,804.12	149,281,120.03	89.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,339,353,224.15	1,203,489,271.82	135,863,952.33	89.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,022,983,100.00	907,473,086.15	115,510,013.85	88.7
210101	Үндсэн цалин	698,733,200.00	634,143,955.53	64,589,244.47	90.8
210102	Нэмэгдэл	276,294,900.00	237,331,004.27	38,963,895.73	85.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	47,955,000.00	35,998,126.35	11,956,873.65	75.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,873,600.00	112,451,936.71	15,421,663.29	87.9
210201	Тэтгэврийн даатгал	86,954,100.00	78,579,818.33	8,374,281.67	90.4
210202	Тэтгэмжийн даатгал	10,229,900.00	9,252,918.33	976,981.67	90.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,183,900.00	7,261,534.51	922,365.49	88.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,000.00	1,577,969.56	468,030.44	77.1
210205	Эрүүл мэндийн даатгал	20,459,700.00	15,779,695.98	4,680,004.02	77.1

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,121,124.15	73,121,124.15	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	18,971,624.15	18,971,624.15	-	100.0
210302	Түлш, халаалт	41,249,500.00	41,249,500.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	12,900,000.00	12,900,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	5,490,600.00	5,490,600.00	-	100.0
210502	Хоол, хүнс	5,490,600.00	5,490,600.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,924,500.00	9,924,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	9,924,500.00	9,924,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,997,200.00	9,921,000.00	1,076,200.00	90.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,956,000.00	2,956,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,041,200.00	6,965,000.00	1,076,200.00	86.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,963,100.00	85,107,024.81	3,856,075.19	95.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,904,600.00	72,051,174.81	3,853,425.19	94.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,058,500.00	13,055,850.00	2,650.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,234,700.00	83,817,532.30	13,417,167.70	86.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,234,700.00	83,817,532.30	13,417,167.70	86.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,874,000.00	52,456,832.30	13,417,167.70	79.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,360,700.00	31,360,700.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,436,587,924.15	1,436,588,886.85	(962.70)	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,258,408,400.00	1,258,408,400.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,258,408,400.00	1,258,408,400.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,045,624.15	83,045,624.15	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	83,045,624.15	83,045,624.15	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	95,133,900.00	9,478,248.00	85,655,652.00	10.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,956,000.00	2,956,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,522,300.00	6,522,248.00	52.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	85,655,600.00		85,655,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		85,656,614.70	(85,656,614.70)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		149,281,120.03	(149,281,120.03)	

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53	53	-	
620001	Удирдах ажилтан	3	3	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	-	
620003	Үйлчлэх ажилтан	18	18	-	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	501	503	-	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	501	503	-	
630001	Төрийн өмчит ЕБС	501	503	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь “Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэгтэй, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай, эрүүл зөв хүүхэд, хамт олныг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурлагын амжилтыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн, танхимын болон танхимын бус сургалтын хэлбэрүүдээр хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэн, сургалтын үйл ажиллагааны чанарыг ахиулан хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Суралцагчдын 3-4 математик, 5-6 англи хэлний сургалтыг дэмжих цахим технологид суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах.
- Хүүхэд бүрийн онцлог ялгаатай хэрэгцээг үндэслэн тэгш хамруулан суралцах, хөгжих, эрүүл аюулгүй амьдрах зөв дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, эрсдэлийг бууруулах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх.
- Багшийн хөгжлийг мэргэжлийн хөгжлийн бүлгээр дэмжиж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих, дижитал технологийг сургалтад үр дүнтэй ашиглах, шинэлэг арга зүйд суралцах, хөтөлбөр болон даалгаврын санг үр дүнтэй ашиглах, ур чадвар, үр өгөөжийг тооцох.
- Дунд, ахлах ангийн суралцагчдад ажил, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэн сонгох хичээлийн амжилт, чанарыг бататган ахиулах Medle.mn нэгдсэн платформыг ашиглан сайн сургах, сурагчдыг шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг улирал бүр тооцон ажиллах.

- Багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн, эрүүл аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлэх эцэг эхийн оролцоо, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэн, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах, ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг үр ашигтай зарцуулах, тайлагнах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06, 5 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон.*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
 - 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*
 - 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,428.9 мянган төгрөгөөр буюу 1,79 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	85,656.6	149,281.1	63,624.5
Авлага			
Бараа материал	124,292.2	133,941.9	9,649.7
Үндсэн хөрөнгө	1,986,741.6	1,952,896.3	(33,845.3)
Нийт хөрөнгө	2,196,690.4	2,236,119.3	39,428.9
Өр төлбөр	12.1	458.4	446.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,196,678.3	2,235,660.9	39,892.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,196,690.4	2,236,119.3	39,428.9

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 149,281.1 мянган төгрөг болж 63,624.5 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 133,941.9 мянган төгрөг болж 9,649.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 1,860.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,949.9 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй орлого авч, сургуулийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн 6,213.8 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг акталснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,952,896.3 мянган төгрөг болж, 33,845.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 9,743.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 11,970.0 мянган төгрөгийн ширээ сандал, “Хүүхэд залуусын амжилтын үндэс” төсөл хөтөлбөрөөс 14,589.8 мянган төгрөгийн цахилгаан хөгжим үнэ төлбөргүй орлого авснаас голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,013,497.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 84,012.5 мянган төгрөг, нийт 1,097,509.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ингэснээр улсын төсвөөс 1,258,408.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 83,045.6 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,956.0 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 6,522.3 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 85,655.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр, төсвийг нийт 1,436,587.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,258,408.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 83,045.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 85,655.6 мянган төгрөг нийт 1,436,587.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,287,306.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,287,306.8 мянган төгрөг буюу 89.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 135,864.9 мянган төгрөгөөр, үдийн цай

хөтөлбөрийн зардлыг 13,416.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-Байр ашиглалт	3,216.5	3,211.1	5.4	100
2	80312- сургалт семинар	2,979.8	2,555.8	424.0	100
3	81605 - Эрүүл мэндийг дэмжих	5,363.8	2,269.0	3,094.8	42.3
4	81801- үдийн цай	65,874.0	52,457.8	13,416.2	79.6
5	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	33,527.7	33,490.0	37.7	99.9
6	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	8,722.7	8,432.0	290.7	96.7
7	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	987,848.5	888,217.6	99,629.9	89.9
8	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	246,009.3	213,626.9	32,382.4	86.8
9	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сур нэмэлт	5,525.6	5,525.5	0.2	100
10	81848-Түрээсийн номны	2,956.0	2,956.0	-	100
11	83603-дээд шатны төсвөөс	996.7	995.4	1.3	99.9
	Дүн	1,353,542.3	1,204,262.1	149,281.1	89
12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	83,045.6	83,045.6	(0.0)	100
	Нийт	1,436,587.9	1,287,306.8	149,281.1	89.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Ундрах тум” ХХК, “Галил этоос” ХХК, “Сэлэнгэ титан” ХХК, “Алтан тариа” ХХК, “Хэрсэн чулуу” ХХК болон иргэн Ц.Оюун эрдэнэ, М.Мөнхцэцэг,

О.Цэрэнпагма нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн ахлах аудитор О.Чулуунбаатар, аудитор Ю.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,108,853.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,088.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 166 мэдээллийг байршуулахаас 2 төрлийн мэдээг хоцроосон байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт сарын мэдээнээс 2 удаагийн мэдээг,
- Дараа жилийн төсвийн төсөл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу тус сургуулийн нягтлан бодогч Б.Даваанямд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 65,874.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Ундрах тум” ХХК, “Галил этоос” ХХК, “Сэлэнгэ титан” ХХК, “Алтан тариа” ХХК, “Хэрсэн чулуу” ХХК болон иргэн Ц.Оюун эрдэнэ, М.Мөнхцэцэг нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3

дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлагын бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Албан шаардлага	1	911.0	1	911.0
Нийт дүн	1	911.0	1	911.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнээгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **1,982.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Б.Давааням 1,114.0 мянган төгрөг,
- Нярав Г.Баярсайханд 868.0 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 458.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ, ХХОАТ-ын 458.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн.	1	458.4			1	458.4						
Дүн	1	458.4			1	458.4						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1					
Дүн	1				1					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	1				1					